



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГА, ДҮҮРГИЙН ОНЦГОЙ
КОМИССЫН ДАРГА Н.АЛТАНШАГАЙ
ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ж.Самбуугийн гудамж 11, Засгийн газрын XI байр,
Утас: 26 09 75, Факс: (976-11) 32 69 75,
E-mail: gecm@gec.gov.mn, http://www.gec.gov.mn

2021.09.16 № 1/354
танай _____-ны № _____-т

**Хуулийн тогтоомжийн хэрэгжилтийг
ханган ажиллах тухай**

Монгол Улсын Их Хурлын 18, 28 дугаар тойрогт явагдах нөхөн сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах явцад Коронавируст халдвар /Covid-19/-аас урьдчилан сэргийлэх, сонгуулийн тухай хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангаж, ажиллах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, хороодын Засаг дарга нарт дараах үүрэг, чиглэлийг өгч хамтран ажиллахыг хүсье. Үүнд:

1. Холбогдох мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийн дагуу Коронавируст халдвар /Covid-19/-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмжийг чанд мөрдөх, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 152 дугаар тогтоолоор батлагдсан “түр журам”-ын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж ажиллах,

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.17-д “Сонгуулийн хороог аюулгүй байдлыг хангасан ажиллах байр, тээвэр, холбооны болон бусад шаардлагатай хэрэгслээр хангах асуудлыг тухайн шатны Засаг дарга хариуцна.” гэж заасан. Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.2, 62.4, 62.5 дахь хэсэг, Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан “Санал авах байранд тавигдах ерөнхий шаардлага”, “Санал авах байр бэлтгэх заавар”-т тус тус нийцүүлэн сонгуулийн хороодын байр болон санал авах байрыг бэлтгэж, сонгуулийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах,

3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-д зааснаар нэр дэвшигчээс сонгогчидтой хийх уулзалт, хурал, цуглаан хийхэд нь зориулж төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн 51 хувь ба түүнээс дээш оролцоотой хуулийн этгээд нь өөрийн эзэмшиж байгаа соёлын төв, биеийн тамирын болон хурлын заал, бусад байр, танхимыг үнэ төлбөргүй ашиглуулах үүрэгтэй.

Мөн хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т “нэр дэвшигчдээс сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан зохион байгуулах үйл ажиллагаанд бүх шатны Засаг дарга дэмжлэг үзүүлж, сонгуульд оролцогч талуудад тэгш хандах үүрэгтэй.” гэж заасан. Иймд дээр дурдсан хуулийн этгээдийн хурлын заал, бусад байр, танхимыг нэр дэвшигчдээс сонгогчидтой хийх уулзалт, хурал, цуглаан зохион байгуулах үйл ажиллагаанд зориулан үнэ төлбөргүй ашиглуулах, нэр дэвшигчдэд тэгш хандах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах,

4.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1-д зааснаар эрүүл мэндийн байдлын улмаас санал авах байранд өөрийн биеэр очиж чадахгүй сонгогч зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар саналаа өгөх боломжтой. Мөн хуулийн 63 дугаар зүйлийн 63.3-д зааснаар эрүүл мэндийн байдлын улмаас санал авах байранд өөрийн биеэр очиж чадахгүй сонгогч нь асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй бол тухайн сонгогчийн харьяалагдах баг, хорооны Засаг дарга зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар саналаа өгөх тухай түүний хүсэлт, мэдээллийг холбогдох хэсгийн хороонд хүргүүлэх үүрэгтэй.

Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 152 дугаар тогтоолоор батлагдсан “түр журам”-ын 6 дугаар бүлэг, Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 15 дугаар тогтоолоор батлагдсан “Сонгогчийн саналыг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар авах нийтлэг журам”-д тус тус заасны дагуу эрүүл мэндийн байдлын улмаас санал авах байранд өөрийн биеэр очиж чадахгүй сонгогчийн сонгох эрхийг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах,


5.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1-д зааснаар санал авах өдөр буюу 2021 оны 10 дугаар сарын 10-ны өдөр согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах, соёл урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулах, гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төв ажиллахыг хориглох, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах,

6.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосон дээрх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахдаа коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр Улсын онцгой комиссоос сонгууль зохион байгуулалтын үйл ажиллагаанд зориулан тусгайлан гаргасан чиглэл, мэргэжлийн байгууллагын зөвлөмжид нийцүүлэн, хэрэгжилтийг хангаж ажиллах,

7.Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 152 дугаар тогтоолоор батлагдсан “түр журам”-н хэрэгжилтийг хангах зорилгоор сонгогчдыг нэг удаагийн маск, бээлийгээр хангах, санал авах байранд эрүүл мэндийн болон онцгой байдлын нийт 2 хүн ажиллуулах, тэдгээрийн хоол, урамшлын зардлыг шийдвэрлэх.

Хүндэтгэсэн:

ДАРГА



П.ДЭЛГЭРНАРАН